**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 25 өдөр　　　　Дугаар А/194　　　　Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон шинэ хаяг авсан 4 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Ж.Өлзийжаргал)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/364 дүгээр захирамжийн хавсралтын 26 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА　　　　Ц.МӨНХБАТ

4822100275

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/124 дугаар захирамжийн хавсралт

| № | Өмчлөгчийн | | | Өмнөх захирамжийн | | Өмнөх газрын | | Газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Байршил | Хэмжээ /м2/ | Хэмжээ /м2/ | Байршил | Үнэ /төгрөг/ |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1 | Лувсанжамба | Мөнхбаяр | ЗЭ76110817 | | | Айраг 8-5 | 727 | 615 | Айраг 6-612 | 1230000 |
| 2 | Лувсанжамба | Мөнхбаяр | ЗЭ76110817 | | | Айраг 8-6 | 465 | 705 | Айраг 6-614 | 1410000 |
| 3 | Эрдэнэчулуун | Гансүх | ЗЮ93072510 | 2017.10.19 А/364 | 26 | Говь 14-1444 | 900 | 900 | Тосгон 9-912 | 1350000 |
| 4 | Далх | Цэгмэд | ЗЮ44100506 | | | Задгай 1-2 | 3500 | 3023 | Их тойруу 6-617 | 9069000 |